



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0252 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3,444,444.45 (гурван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 688,888.92 (зургаан зуун наян найман мянга найман зуун наян найман төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Хьюндай Соната-7 маркийн 3388 ХЦА улсын дугаартай автомашиныг хавсралтад заасны дагуу Боловсролын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2025 оны 02 дугаар сарын 08 ны өдрийн  
 3-с дугаар тогтоолын хавсралт



ХИЛ ХАМГААЛАХ ӨРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН 0252 ДУГААРАНГИЙН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Ашиглах хугацаа	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Хьюндай Соната-7 /Арал № КМНЕС41LBEA586039/	1/1/2012	3.00	3,444,444.45	688,888.92	Боловсролын яаманд
				<b>3,444,444.45</b>	<b>688,888.92</b>	
Нийт дүн				(гурван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун дөчин дөрвөн төгрөг дөчин таван мөнгө)	(зургаан зуун наян найман мянга найман зуун наян найман төгрөг ерэн хоёр мөнгө)	